



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/42

Улаанбаатар хот

Албан томилолтоор ажиллуулах тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4 дэх хэсэг, "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хөдөлмөрийн дотоод журам"-ын 11.1.1, 11.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн өмчийг эзэмшүүлэх 2022 оны гэрээг дүгнэх, татан буугдсан Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын "Үл хөдлөх хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай" Засгийн газрын 2023 оны 109 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж холбогдох байгууллагуудад үл хөдлөх хөрөнгө, газар эзэмших эрхийг шилжүүлэх, байрлан үйл ажиллагаа явуулах байгууллагын асуудлыг судлан, санал бэлтгэх үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, хуваарь, шаардагдах зардлын төсвийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

2.Ажлын хэсгийн орон нутагт ажиллах удирдамжийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

3.Алба хаагчдын унаа, томилолтын зардлыг зохих журмын дагуу тооцож, дотоод томилолтын зардлаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогч /Д.Отгонтуяа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

132013552

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 08 дүгээр сарын 21-ны өдрийн
Ажлал: Тоот тушаалын хавсралт

**ТӨРИЙН ӨМЧИЙГ ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭ БАЙГУУЛАХ, ДҮГНЭХ,
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗРЫН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙГ ХҮЛЭЭЛЦЭХ
(ГЭРЭЭ БАЙГУУЛАХ) АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ХУВААРЬ, ТӨСӨВ**

Д/д	Аймгийн нэр	Ажлын хэсэг		Ажил- лах хүний тоо	Ажил- лах хоног	Томилолтын зардал	Замын зардал		Нийт зардал
		Нэр	Албан тушаал				(аймаг автомашин /шатахуун/		
	Архангай, Өвөрхангай, Баянхонгор								
1	Баянхонгор			2	3	708,000.00		225,855.00	933,855.00
2	Архангай	Б.Сүнжидмаа Т.Мөнхбаяр	ТӨБАХ-ийн мэргэжилтэн	2	2	472,000.00		169,875.00	641,875.00
3	Өвөрхангай /Хархорин/			2	3	708,000.00		171,954.00	879,954.00
	дүн				8	1,888,000.00		567,684.00	2,455,684.00
	Дархан, Сэлэнгэ								
4	Дархан-Уул	Д.Тунгалагтуул Л.Гэрэлмаа	ТӨБАХ-ийн ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн	2	3	852,000.00		78,511.50	930,511.50
5	Сэлэнгэ, Зүүнхараа			2	3	708,000.00		171,750.00	879,750.00
	дүн				6	1,560,000.00		250,261.50	1,810,261.50
	Булган, Хөвсгөл, Орхон								
6	Хөвсгөл			2	3	708,000.00		268,875.00	976,875.00
7	Орхон	Э.Дуламсүрэн, Р.Ширчинням	ТӨБАХ-ийн мэргэжилтэн	2	2	568,000.00		291,375.00	859,375.00
8	Булган			2	2	472,000.00			472,000.00
	дүн				7	1,748,000.00		560,250.00	2,308,250.00
	Өмнөговь, Дундговь, Төв								
9	Өмнөговь			2	3	708,000.00		198,250.50	906,250.50
10	Дундговь	М.Баярмаа, П.Уранмандах	ТӨБАХ-ийн мэргэжилтэн	2	2	472,000.00			472,000.00
11	Төв			2	2	472,000.00		225,259.50	697,259.50
	дүн				7	1,652,000.00		423,510.00	2,075,510.00

(төгрөгөөр)

Д/д	Аймгийн нэр	Ажлын хэсэг		Ажил-лах хүний тоо	Ажил-лах хоног	Томилолтын зардал	Замын зардал		Нийт зардал
		Нэр	Албан тушаал				(аймаг автомашин /шатахуун/)		
	Завхан, Говь-Алтай								
12	Говь-Алтай	Б.Мөнхбаатар	ТӨБАХ-ийн ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн	2	3	708,000.00	435,958.00		1,143,958.00
13	Завхан (Тосонцэнгэл)	Р.Ширчинням	ТӨБАХ-ийн ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн	2	3	708,000.00	436,800.00		1,144,800.00
	дүн				6	1,416,000.00	872,758.00		2,288,758.00
	Дорнод, Хэнтий, Сүхбаатар								
14	Дорнод	Д.Нарангэрэл	ТӨБАХ-ийн дарга, мэргэжилтэн	2	3	708,000.00	306,256.50		1,014,256.50
15	Хэнтий	Т.Мөнхбаяр	ТӨБАХ-ийн дарга, мэргэжилтэн	2	2	472,000.00	289,309.50		761,309.50
16	Сүхбаатар		ТӨБАХ-ийн дарга, мэргэжилтэн	2	2	472,000.00			472,000.00
	дүн				7	1,652,000.00	595,566.00		2,247,566.00
	Дорноговь, Говь-Сүмбэр, Замын-Үүд								
17	Говь-Сүмбэр		ТӨБАХ-ийн дарга, мэргэжилтэн	2	2	472,000.00			472,000.00
18	Дорноговь	Э.Дуламсүрэн	ТӨБАХ-ийн дарга, мэргэжилтэн	2	3	708,000.00	163,476.00		871,476.00
19	Замын-Үүд	Д.Батболд	ТӨБАХ-ийн дарга, мэргэжилтэн	2	2	256,000.00	350,622.00		606,622.00
	дүн				7	1,436,000.00	514,098.00		1,950,098.00
	Баян-Өлгий, Ховд, Увс								
20	Баян-Өлгий		ТӨБАХ-ийн ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн	2	3	708,000.00	612,676.50		1,320,676.50
21	Ховд	Б.Мөнхбаатар	ТӨБАХ-ийн ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн	2	3	708,000.00			708,000.00
22	Увс	Д.Батболд	ТӨБАХ-ийн ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн	2	3	708,000.00	601,647.00		1,309,647.00
	дүн				9	2,124,000.00	1,214,323.50		3,338,323.50
	Нийт зардал					13,476,000.00	4,998,451.00		18,474,451.00

Хянасан:

Захиргаа удирдлагын хэлтсийн дарга

Ерөнхий нягтлан бодогч

Боловсруулсан:

Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн

Н.Ганболд

Д.Отгонтуяа

М.Баярмаа

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн
А/4 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

Албан томилолтын ажлын удирдамж

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 715 тогтоол, тус тогтоолоор баталсан аргачлалын дагуу Төрийн өмчийг эзэмшүүлэх 2022 оны гэрээний биелэлтийг хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт, хөрөнгийн хөдөлгөөн, бүртгэл, мэдээ тайлан, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, тайлагналтын байдал, газар эзэмших, ашиглах эрхийн байдал, Төрийн болон орон нутгийн өмчийн цахим мэдээллийн системд захиргааны статистикийн мэдээг оруулсан байдал зэрэг үндсэн шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ.

Тухайн аймаг, орон нутагт байгаа бүх төрийн өмчит байгууллагын хамруулан сургалт зохион байгуулж тооллого, өмч эзэмшлийн гэрээний дүнгээр гарсан зөрчил дутагдлын талаар анхааруулга, зөвлөмж өгнө.

Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ дүгнэх ажилд дараах тогтоол, шийдвэрийн биелэлтийг хянаж, үнэлэлт дүгнэлт өгнө:

- Засгийн газрын 2022 оны 481 дүгээр тогтоолын хэрэгжилтийн байдлыг хянаж, дүгнэлт гаргах
- Улсын үзлэг, тооллогоор илэрсэн зөрчил дутагдал, өнгөрсөн жилийн ӨЭГ дүгнэхэд илэрсэн зөрчил дутагдлыг арилгасан байдалд хяналт тавих
- Газар эзэмших эрхийн бүртгэлд ямар зөрчил байсан, түүнийг хэрхэн шийдвэрлэснийг системээс тодруулж, үнэлэлт дүгнэлт өгөх
- Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажил байдалд үнэлгээ өгөх
- Төрийн өмчит бүх байгууллагаар орж үзэх, барилга байгууламжид үзлэг хийх явцад түрээсийн асуудлыг шалгах
- Дуудлагын худалдаанд онцгой анхаарал хандуулж, холбогдох журам, зааврын дагуу явуулсан эсэхийг нягтлах,
- Түрээсийн гэрээ байгуулсан байдал, бодит түрээс, төлбөр төлөлт, сонгон шалгаруулалтын баримттай танилцан дүгнэлт гаргах.

Монгол Улсын Засгийн Газрын “Үл хөдлөх хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай” 109 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангуулах зорилгоор Татан буугдсан Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын харьяа аймаг дахь барилга, байгууламж, газар эзэмших эрх, болон тогтоолд заасан хөрөнгийг холбогдох байгуулагуудад хүлээлцэх ажлыг газар дээр нь зохион байгуулж, байршуулах асуудлыг судална.

Төрийн өмчөөс орон нутгийн өмчид шилжүүлэх Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөлд тусгагдсан хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийг холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгч, ашиглалтын гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг Татан буулгах комиссын 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаанаас гарсан саналын дагуу Мэргэжлийн

хяналтын ерөнхий газрын харьяа аймаг дахь конторын барилгад байршин үйл ажиллагаа явуулах байгууллагын өрөө тасалгааны талбайг тооцон гаргаж, санал бэлтгэх.

Төв, орон нутгийн Мэргэжлийн хяналтын байгууллагуудын эзэмшилд бүртгэлтэй, байцаагч нарын ашиглаж байсан хөдлөх хөрөнгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 114, 115, 116, 117, 118, 119, 120, 121, 122, 123, 124, 125, 126, 127, 128, 129, 130, 131, 132 тогтоолоор холбогдох яам, агентлагийн харьяа газарт балансаас балансад шилжүүлсэн хөрөнгийг хүлээлцэх ажлыг зохион байгуулж, тогтоолын хэрэгжилтийг хангуулах.

Ажлын тайланг цахим системд оруулж, нэгдсэн тайлан бэлтгэж дүнг Газрын хуралдаанд танилцуулна.

оОо